

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл

"Сүхбаатар" Эрүүл мэндийн нэгдэл нь Монгол улсын ЭМЯ, НЭМГ, Сүхбаатар дүүргийг ЗДТГ-ын бодлого чиглэл, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн 2дахь тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага.

Эрүүл мэндийн нэгдэл нь Улаанбаатар хотын АДРГЗ-ны ЭХГ-н даргын 1970 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 126 дугаар тушаалаар "Хүүхдийн 2 эмнэлэг" нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, амбулатори, больниц, тусгай тасаг, захиргаа аж ахуйн тасаг-тайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Хүүхдийн эмнэлгийн анхны даргаар Ж.Уртнасан/1970-1977/

Монхор 1977-1981/ С.Ёндонцоо /1983-1997/, Ц.Тогообат /1997-2001/, М.Чимгээ /2001-2004/ О.Бямбаа 2004 оны 2 дугаар сараас ЭМН-н даргаар ажиллах болсон.

Сүхбаатар дүүргийн ЭМН-н нийслэл хотын хоймор төв хэсэгт байрлаж, Поликлиник, салбар амбулатори №1,2 өрхийн 18 -н эмнэлгийн гэсэн бүтэцтэй нийт 305 ажилтантай, үүнээс их эмч 131, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 114, захиргаанд 18, аж ахуйн үйлчилгээнд 42 ажилтантайгаар Нийгмийн эрүүл мэндийн анхан болон 2 дохь шатлалын тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлж байна. Оношлог оо, эмчилгээний 22 төрлийн нарийн мэргэжлийн кабинеттай өдөрт 500 хүнд үйлчлэх хүчин чадалтай хүн амын өсөлт, тэдний эмнэлгийнх тусламж үйлчилгээ авах хэрэгцээнээс шалтгаалан өдөрт дунджаар 800-1200 хүнд үйлчилдэг. Нэгдсэн лаборатори, рентген, эхограф, уян дурангийн оношлог оо, хүүхэд, дотор мэдрэл, нүд, чих, хамар хоолой, шүд, арьс, харшил, зүрх судас булчирхайн сэтгэц, эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үе, ДОХ*БЗДХ, сургалт, мэс засал, гэмтэл, халдвар, ахмад, зүрх судас, үзлэгийн кабинетуудтай.

Зорилго: Дүүргийн хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, шударга, чанартай, үзүүлж, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэн, "Эрүүл иргэн", "Эрүүл өрх", "Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлэн үйл ажиллагааг нь дэмжих, улмаар насжилтыг уртасгах зорилготойгоор үйл ажиллагаа явуул ана. 2006 онд салбар амбулатори 2-г шинээр байгуулан, 34 хүний ажиллах орон тоог батлуулан 12 өрхийн эмнэлгийн байрны асуудлыг шийдвэрлэсэн.

2001 он Нийслэлийн ЭМГ-ын даргын шийдвэрээр СБД-ийн нутаг дэвсгэрт байрлах Эрүүл мэндийн 16-р төвийг ЭМН-д нэгтгэн зохион байгуулав.

2004 онд НЭМГ-аас тендер зарлаж ЭМН-ийн хэвтүүлэн эмчлэх больницыг менежментийн гэрээгээр ЭМН-ийн дарга М.Чимгээ ахлагчтай баг шалгарч "Сүхбаатар" нэгдсэн эмнэлэг нэртэйгээр тусад нь ажиллуулах болсон.